

“ШҮҮМЖЛЭЛ ӨГҮҮЛЭЛ” ЗОХИОЛ ДАХЬ КҮНЗИЙН “АЧЛАЛ”-ЫН ТУХАЙ ҮЗЭЛ СУРГААЛ

С.Янжинсүрэн, доктор (Ph.D), профессор
МУИС, Философи, шашин судлалын тэнхимийн багш

Д.Юмчинхорлоо, докторант
Бээжингийн Төвийн Үндэстний их сургууль

Түлхүүр үг: Күнз (孔子), “Шүүмжлэл өгүүлэл” (论语); ачлал (孝); өршөөл (仁); гэр бүлийн ёс суртахуун

Товч агуулга: Эртний Хятадын Хавар Намар Улсын (春秋)¹ үе бол хятадын түүхэн дэх их өөрчлөл шинэчлэлийн үе гэгддэг. Учир нь энэ үед хятадад улс төр, эдийн засаг, соёл зэрэг нийгмийн амьдралын бүхий л хүрээнд ихээхэн өөрчлөлт бий болсноос тухайлбал боловсролын хүрээнд зөвхөн язгууртан гаралтай хүмүүсийг сургадаг, түшмэл-багштай “төрийн сургууль”-ийн нөгөө талд “хувийн сургууль” хөгжиж эхэлжээ. Ингэснээр эрдэмтэн мэргэд хувь хувьдаа шавь элсүүлэх болж, ноёд түшмэдийн боловсрол ард олны дунд түгэх болов². Энэ нь аажимдаа эртний Хятадад “цэцгэсийг дэлгэрүүлж, эрдэмтдийг цэцлүүлэх” (百家争鸣) нөхцөлийг бүрдүүлжээ.

Энэхүү цаг үед төрөн гарч, үзэл номлолоо боловсруулж, үг сургаалаа айлдаж байсан мэргэдийн нэг нь Күнз юм.

Их сэтгэгч Күнз МЭӨ 551 онд хятадын Лу улс (鲁), одоогийн өмнөд хятадын нутаг Шаньдун мужийн Чү фу хотод төрсөн бөгөөд 2 настайдаа эцгээсээ өнчирч, сахилга бат, дэг журмыг дээдэлдэг ээжийнхээ нөлөөн дор өсөж хүмүүжсэн.

Тэрээр багаасаа сургуульд сурсан хийгээд өндөр мэдлэг, ёс суртахуунтай гэрийн багштай байсан зэрэг нь түүний үзэл санаа төлөвшихөд нөлөөлсөн гэж үздэг.

Күнзийн зохиол бүтээлийн дотор “Шүүмжлэл өгүүлэл” 《论语》 зохиол нь түүний сургаал номлолыг илэрхийлэх чухал эх сурвалжийн нэгд зүй ёсоор тооцогддог. Күнзийн үзэл сургаалын хамгийн гол ойлголт нь “өршөөл” (仁) бөгөөд “өршөөл”-ийн суурь нь “ачлал” (孝) хэмээх ойлголт болдог.

Энэхүү өгүүлэлд “Шүүмжлэл өгүүлэл” зохиолд Күнзийн “ачлал”-ын тухай үзэл сургаал хэрхэн илэрч байгааг өгүүлэхийг зорилоо.

Удиртгал

Күнзийн эцэг Шу Лианг Гэ (叔梁纥) (МЭӨ 622-549) бээр нэн зоригтой, дайчин, үнэнч шударга бөгөөд биерхэг, сайхан эр байсан гэж хятадын ард түмний дунд домог болгон ярьдаг.

Күнзийн эцэг эхнэр авч олон жил болоход 9 охинтой болсон тул удам залгах хүүтэй болох хүсэлдээ хөтлөгдөн бараг 60 хүрсэн хойноо 2 дахь эхнэрээ авсан гэдэг. Удаахь эхнэрээс нь доголон хөлтэй хүү төрсөнд дахин Янь (颜) овогт, өндөр ёс суртахуунтай, хүмүүжилтэй гэр бүлээс гарал бүхий Жэнь Зай (征在) (МЭӨ 568-537) гэх 16 настай, цэл залуу бүсгүйтэй гэрлэж, хүү төрүүлсэн нь Күнз байжээ. Күнзийн эцэг Шу Лианг Гэ нь түүнийг 2 настайд нас нөгчсөн тул Күнз эхийн хайр халамжид өсөж хүмүүжсэн байна³.

¹ Хавар Намар улс нь МЭӨ 770-476 оны хоорондох үеийг хамарна.

² Эртний Хятадад хамгийн анхны ийм сургуулийг Күнз үндэслэсэн гэж үздэг.

³ Конфуций. Минск. 1998. стр. 196-210

Түүний ертөнцийг үзэх үзэл бүрэлдэн тогтоход ээж нь ихээхэн нөлөөлсөн гэх бөгөөд эх Жэнг Зай нь эцгийнх өмнөх 2 эхнэрээс холдон нүүж, биеэ даан Күнзийг өсгөхдөө өдөр бүр үлгэр, домог ярьж, хятад ардын аман зохиолтай нөхөрлүүлсэн нь Күнзийн ёс зүйн сэтгэлгээ төлөвших оюун санааны нөхцлийг бүрдүүлсэн байна. Тухайн үед хятад хөвгүүдийг 7, 8 наснаас сургуульд хамруулдаг байсан тул Күнз ч тэр ёсоор сургуульд элсчээ.

Күнзийн анхны багш Янь овогт бээр тухайн үедээ өндөр боловсрол, соёлтой, ёс суртахуунтай хүн байсан нь түүний нийгэм улс төр, ёс зүйн сэтгэлгээ төлөвшиж, хөгжихөд хүчтэй нөлөөлжээ. Янь багш Күнзийг ёс зүйн хэм хэмжээнд сургаж, өөрөө багадаа эцэг эхийн үгийг сонсдог, биелүүлдэг, тэдний зөвшөөрөлгүйгээр гадагш гарч нааддаггүй байсан тухайгаа үлгэрлэн хэлж сургахын зэрэгцээ томчуудын яриаг үл таслах, тэдний үгийг үл эсэргүүцэх, тэдэнтэй ярьж байхдаа биеэ шулуун цэх авч явах тэргүүтнийг зааж сургасан гэдэг.

Ингэж залуу Күнз өөрийн эх болон багшийнхаа дэмжлэгтэйгээр нийгмийн язгууртны зан суртахуунд суралцсан бөгөөд 15-16 наснаасаа үзэл сургаалаа боловсруулсаар хожим хятадын их багш болжээ. Тэрээр хэдэн мянган шавьтай бөгөөд тэдний дотроос чамгүй олон нэрт сэтгэгч төрөн гарсны дотор дэлхий дахинаа алдаршсан Мэнз түүний шавь байв. Күнз бүх хятадаар аялан сургаал номоо дэлгэрүүлсэн байна.

Хятадын соёл, сэтгэлгээнд Күнзийн сургаал чухал байр эзэлнэ. Судлаачид Күнзийн сургаал үзэл санааны хамгийн гол ойлголт нь “өршөөл” (仁) гэж үздэг бөгөөд “өршөөл”-ийг үйлдэх, “өршөөл”-тэй байхын суурь нь “ачлал” (孝) буюу аав ээж, ахас ихсээ өргөн тэтгэж, хүндэтгэх юм.

“Ачлал” (孝) нь хятад хүний ахуй амьдрал, уламжлал, зан заншилтай нягт холбогддог тул хятадын өөрийн болон гадаадын эрдэмтэн судлаачид “ачлал” бол хятадын соёлыг бусад соёлоос ялгах гол онцлог, хятадын соёлыг “хятад соёл” болгож байгаа хамгийн чухал хэсэг гэж үздэг. Тухайлбал, Гегель “Түүхийн философи” зохиолдоо: “...Хятад энэхүү ёс суртахууны уялдаа холбоон дээр бий болсон бөгөөд гэр бүл дэх ачлал хүндлэл нь тэдний гол онцлог”⁴ гэжээ. Мөн хятад хэлэнд “百善孝为先” (bai shan xiao wei xian) гэсэн хэлц үг бий бөгөөд энэ нь “хамаг сайн үйлийн хамгийн эх нь ачлал” гэсэн утгатай.

1. “Шүүмжлэл өгүүлэл” зохиолын тухай

“Шүүмжлэл өгүүлэл” нь Күнзийн гүн ухааны урсгалын Дөрвөн ном (四书)⁵ -ын нэг юм. Хятадын Күнз судлаач эрдэмтэн Ян Бо Жүн (杨伯峻) -ий дүгнэсэнчлэн “Шүүмжлэл өгүүлэл” бол “Күнзийн сургаал, үзэл санааг сурах, судлах хамгийн гол эх хэрэглэгдэхүүн”⁶ мөн болно. Энэ нь хятадын гүн ухаанд Күнзийн зохиол бүтээл, тэдгээрийн агуулга, үзэл санаа хүндтэй байрыг эзэлдэг болохыг нотолдог юм.

Күнзийн үг яриа, үйл хэрэг, ялангуяа түүний шавь нартайгаа хэлэлцсэн харилцан яриа хэлбэрээр тэмдэглэсэн “Шүүмжлэл өгүүлэл”-ийг хэзээ, хэн анх эмхэтгэсэн талаар хэд хэдэн санал байдаг ч судлаачдын олонх нь Хавар намар улсын (春秋时期) сүүл үеэс Күнзийг тэнгэрт хальсны дараа Байлдаант улсын эхэн үед (战国时期) (МЭӨ 475-221 он), Жун гүн (仲弓), Зы Юй (子游), Зы Ся (子夏), Зы Гүн (子贡) нар голлон эмхэтгэсэн гэж үздэг.

Улс төр, засаглал, ёс суртахуун, сурган хүмүүжүүлэх зэрэг олон салбарын үзэл санааг багтаах “Шүүмжлэл өгүүлэл” зохиол нь Хятадын эртний Хан улсын үеийн нэрт түүхч, зохиолч Бан гү (班固) -ийн⁷ өгүүлсэнчлэн: “Күнз, түүний шавь нартаа хийгээд сургаал номлолоо айлдах

⁴ 黑格尔: 《历史哲学》, 上海人民出版社1990年版, 第232页。

⁵ Күнзийн гүн ухааны урсгалын “Шүүмжлэл өгүүлэл”, “Мэнз”, “Их суртахуй”, “Хэв дундын ёс”-г хамтад нь ийнхүү нэрлэдэг.

⁶ 杨伯峻: 《译注》, 中华书局, 2009年版, 31页。

⁷ Бангү (МЭ 32-92) Эртний Хятадын Хан улсын үеийн сайд, түүхч, утга зохиол судлаач

үед хүмүүсийн хоорондын асуулт хариулт, мөн түүнчлэн Күнзийн шавь нар багшаасаа сонсож мэдсэнээ хэлэлцэн цэцэлсэн мэтгэлцээн бөгөөд тухайн үед шавь нар нь тус бүрдээ багшаасаа сурч мэдсэнээ тэмдэглэдэг байгаад хожим багшийгаа нас барсны дараа тэмдэглэлүүдээ нэгтгэж эмхэтгэн бүтээжээ.⁸

Түүхэнд Күнзийн гол зохиол “Шүүмжлэл өгүүлэл”-ийн гурван өөр хувилбар байсан гэж үздэг бөгөөд өдгөө уламжлагдан ирсэн “Шүүмжлэл өгүүлэл” нь 20 бүлэг, 492 зүйлтэй. Түүнээс 444 зүйл нь Күнз бээр өөрийн шавь нартайгаа болон тухайн үеийн хүмүүстэй ярьсан харилцан яриа, үлдэх хэсэг нь Күнзийн шавь нарын хоорондын харилцан яриа болох юм.

2. “Шүүмжлэл өгүүлэл” зохиолд Күнз “ачлал”-ын тухай өгүүлсэн нь.

Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл” зохиолд “ачлал”-ын тухай өгүүлснийг хоёр хэсэгт хувааж үзэж болно. Энэ нь:

1. “孝” (xiao) - “ачлал” хэмээх ханз үсэгтэй хэсэг,
2. Дээрх ханз үсэггүй боловч агуулгын хувьд “ачлал”-тай холбогдох хэсэг тус тус болно.

Нэг. “Шүүмжлэл өгүүлэл” зохиолын бүлгээс зургаан бүлэг⁹ арван гурван зүйлд нь “孝” (xiao) буюу “ачлал” хэмээх ханз үсэг тааралддаг. Эдгээрээс нэгдүгээр бүлгийн хоёр дахь хэсэг (Күнзийн шавь Ю зы багшийнхаа санааг хураангуйлан өгүүлсэн), арван есдүгээр бүлгийн арван найм дахь хэсэг (Зэн зы багшийнхаа сургаалыг дамжуулан өгүүлсэн)-ээс бусад нь бүгд “Күнз өгүүллүүн” (子曰) хэмээн тэмдэглэсэн байгаа тул Күнз өөрөө өгүүлжээ гэсэн үг болно.

Тэдгээр “孝” (xiao) - “ачлал”

хэмээх ханз үсэгтэй арван гурван хэсэгт үндэслэн үзвэл “Шүүмжлэл өгүүлэл” зохиолд Күнз “ачлал”-ын талаар дараах 3 байдлаар өгүүлжээ. Үүнд:

1. Ачлал нийгэм ёс журамтай байх үндэс мөн.

Жишээлбэл: “Ю зы өгүүллүүн: Хүмүүн болбоос, эцэг эхээ ачилж, ихэс ахсыг хүндэлвээс дээдэст тэрслэгч цөөн бөлгөө. Дээдэст тэрслэгч үгүй аваас самуун үйлдэхүйд дурлагч үгүй. Эрдэмт сайд эх суурийг бүтээхийг хичээюү. Эх суурь тавибаас ёс журам тогтъюу. Эцэг эхээ ачилж, ахас эхсээ хүндлэх нь өршөөлийн суурь буюу.”¹⁰ ;

“Күнз өгүүллүүн: Дүү нар минь, эцэг эхийнхээ дэргэд ахуйд ачлагтун. Орон гэрээс одохуйн цагт ахас ихсийг хүндлэгтүн. Үгээ цэнэж шударга байгтун. Ард олныг энэрэн, өршөөлт хүмүүнд дөт байгтун. Энэ бүхнийг хичээн гүйцэлдүүлсний хойно эрхбиш тэнхээ чадал үлдвээс эрдэм номыг шимтэн сурагтун.”¹¹

2. Күнз “ачлал”-ыг хэрхэн илэрхийлэх, хэрхэн үйлдвэл зохистой талаар өгүүлсэн байна. Ингэхдээ ачлал нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж болсон гэр бүлийн харилцаанд чухал бөгөөд “Ёсыг эс зөрчих” буюу эцэг, эхийг амьдад нь асрахаас эхэлдэг болохыг онцолжээ. Цаашид эцэг, эх таалал барсан ч асрахуй үргэлжлэх ёстой бөгөөд чухал нь өвөг дээдсийн сургаалыг хойшид үл зөрчих нь ачлал мөн гэж үзжээ.

Тухайлбал: “Мэн И Зы Күнзээс ачлалыг асуув. Күнз өгүүллүүн: Ёсыг эс зөрчих буюу. Хожим Фань Чи Күнзийн тэргийг хөтөлж байх үед Күнз түүнд өгүүллүүн. Мэн Сүн нь надаас ачлалыг асуухуйд би “Ёсыг эс зөрчих” хэмээсэн билээ. Фань Чи асууруун: Энэ юу гэсэн үг буй? Күнз өгүүллүүн: Эцэг эхийг амьд

⁸ 班固《汉书·艺文志》，中华书局，1975年版。

⁹ Сурахуй хэмээхүйн нэгдүгээр бүлэг, Засаглахуй хэмээхүйн хоёрдугаар бүлэг, Өршөөл оршихуйн хэмээхүйн дөрөвдүгээр бүлэг Тай бай хэмээхүйн наймдугаар бүлэг, Эхлэхүй дор хэмээхүйн арван нэгдүгээр бүлэг, Зы Жан хэмээхүйн арван есдүгээр бүлэг

¹⁰ “Шүүмжлэл өгүүлэл” Сурахуй хэмээхүйн нэгдүгээр бүлэг, хоёрдугаар зүйл. Энэхүү өгүүлэлд “Шүүмжлэл өгүүлэл” зохиолоос эшлэхдээ доктор М.Чимэдпээгийн «Күнз «Шүүмжлэл өгүүлэл»» УБ. 2004 орчуулгыг ашигласан болно. Хойшид зөвхөн бүлэг, зүйлийн дугаарыг тэмдэглэнэ.

¹¹ Сурахуй хэмээхүйн нэгдүгээр бүлэг, зургаадугаар зүйл.

ахуйд хэв ёсоор асарч, үгүй болохуйд заншил ёсоор оршоож, тайж тахиж явагтун хэмээсэн үг бөлгөө.”¹²;

“Зы Ю ачлалыг асуув. “Күнз өгүүлрүүн: Өдгөө ачлал хэмээхүй нь зөвхөн эцэг эхээ асран тэжээхүй төдий мэт. Гэтэл морь, нохойг мөн адил тэжээдэг бус уу. Эцэг эхээ эс хүндлэн ачилбаас морь, нохой тэжээхээс юуны ялгал буй.”¹³;

“Хэрэв эцгийн сургасан ёс журмыг хэдэн жилийн дотор эс зөрчөөс ачлалт хэмээж болох буюу.”¹⁴

3. Төр, засаглалын үйл хэрэгт “ачлал” нөлөөтэй тухайд өгүүлжээ.

“Жи Зан Зы асууруун: Ард олныг хүндлэлтэй шударга болгож хөхиүлэхийн тулд хэрхвээс зохино? Күнз өгүүлрүүн: “Төв хичээнгүй хандваас тэд дээдлэн биширч, ачлан нигүүлсвээс алив сэтгэл хүчээ шавхах бөлгөө. Шударга сайныг нь өргөж, чадал мөхсийг нь гэгээрүүлбээс хөхин урамших бөлгөө.””¹⁵;

“Нэгэн хүн Күнзээс асууруун: Та яагаад засаглалд эс зүтгэнэ вэ? Күнз өгүүлрүүн: “Засагт ном”-д: Ачлал болбоос, эцэг эхээ ачилж, ахан дүүсээ энэрэх аваас тэрхүү сэтгэл засаглалд түгэн хүртъюу” хэмээсэн бөлгөө. Энэ нь нь засаглалд зүтгэж буй хэрэг бус уу, хэрхэхийг засаглалд зүтгэв хэмээх буюу.”¹⁶

Хоёр. “Шүүмжлэл өгүүлэл” зохиолд хэдийгээр “孝” (xiao) - “ачлал” хэмээх ханз үсэггүй боловч агуулгын хувьд “ачлал”-ын үзэл санааг агуулсан зүйл нэлээд бий. Тэдгээр хэсгүүд нь ерөнхийдөө “ачлал” нь гэр бүлд ёс суртахуун төлөвшихөд онцгой үүрэгтэйг тодорхойлсон байдаг.

Тухайлбал: “...Эцэг эхээ тойлохуйд

¹² Засаглахуй хэмээхүйн хоёрдугаар бүлэг, тавдугаар зүйл.

¹³ Засаглахуй хэмээхүйн хоёрдугаар бүлэг, долдугаар зүйл.

¹⁴ Сурахуй хэмээхүйн нэгдүгээр бүлэг, арван нэгдүгээр зүйл.

¹⁵ Засаглахуй хэмээхүйн хоёрдугаар бүлэг, хорьдугаар зүйл.

¹⁶ Засаглахуй хэмээхүйн хоёрдугаар бүлэг, хорин нэгдүгээр зүйл.

¹⁷ Сурахуй хэмээхүйн нэгдүгээр бүлэг, долоодугаар зүйл.

¹⁸ Өршөөл оршихуй хэмээхүйн дөрөвдүгээр бүлэг, арван есдүгээр зүйл.

¹⁹ Өршөөл оршихуй хэмээхүйн дөрөвдүгээр бүлэг, хорин нэгдүгээр зүйл.

²⁰ 查昌国:《西周“孝”义初探》《中国史研究》, 1993年, 第二期。转引自肖群忠:《孝与中国文化》, 人民出版社, 2001年版, 第14页。

энэ биеэ үл гамнах, эзэн ноёнд шадарлахуйд амь насаа зольж чадах, анд нөхөр лүгээ ханилахуйд ам хэл андуугүй бат, ийм хүмүүн хэдийгээр эрдэм номд гэгээрээгүй боловчиг, би бээр түүнийг эрдэмт хүмүүн хэмээмүй.”¹⁷ ; “Эцэг эхийн буйд алсад бүү одогтун, эрхгүй алс одвоос хүрэх газар бас буй.”¹⁸ ; “Эцэг эхийн нас сүүдрийг эс санаваас үл больюу, нэгэнтээ урт насалваас баяснам, нэгэнтээ улам өтлөхүйд эмээнэм.”¹⁹ гэх зэргээр эцэг эхээ асрахуй нь нэгэн зүйлийн эрдэм мөн бөгөөд тийм хүнийг хүндэлбэл зохих тухайд өгүүлсэн байна.

3. Күнзийн “ачлал”-ын тухай үзэл санааны онцлог

“Ачлал”-ын тухай ойлголт, үзэл санаа хятадад нэн эрт бүр тодруулбал, Баруун Жоу (西周) (МЭӨ 1046-771) улсын үеэс өмнө бий болсон гэж үздэг. Гэвч тухайн үеийн “ачлал” нь өдгөө нийтээр ойлгож байгаа аав ээж, ахмад буурлаа өргөн хүндлэх, ачлах утгаас илүүтэйгээр өвөг дээдсийн шүтлэгийн шинжтэй байжээ. Иймээс ихэнхдээ тайлга тахилгаар илэрдэг байсан байна. Энэ тухай хятадын эрт үеийн гүн ухааны түүхийн судлаач Ча Чан гуо (查昌国) : “Баруун Жоу улсын үед “ачлал”-ыг амьд ахуй хүнд үзүүлдэггүй байсан... үүгээрээ Күнз, Мэнзийн “ачлал”-аас ялгаатай.”²⁰ гэжээ.

Үүнээс Күнзийн “ачлал”-ын тухай үзэл санааны онцлогийг дараах байдлаар авч үзэх боломжтой.

1. Күнз “ачлал” (孝) -ийг хүн төрөлхтний ёс суртахууны түгээмэл эрэлхийлэл, зарчим болгон дэвшүүлсэн бөгөөд хүний мөн чанарын онцлог болгож үзжээ. Ингэснээр хятадад эртний Баруун Жоу улсын үеэс овгийн эрх, давхраажлыг (宗法) хамгаалах хэрэгсэл болж байсан “ачлал”-ыг хүн бүрд байх ёс суртахууны

хэм хэмжээ болгож, “ачлал”-ыг хүмүүнлэг шинжтэй болгожээ.

2. “Ачлал” нь цусан төрлийн холбоог чухалчлах сэтгэлзүйгээс үүсэлтэй. Учир нь зохиолд дээр үлгэрлэсэнчлэн гэр бүл, эцэг эхийг амьдад нь ачлах, нас барсны дараа нь тэднийг хүндэтгэлтэйгээр оршуулах, оршуулсны дараа сүнс, сүлдийг нь тогтмол тайж, тахих, хүндэлсээр байх тухай өгүүлсэн байдаг.

Күнз “ачлал” бол хүн бүрийн ёс суртахууны хүмүүжлийн агуулгатай болохоос шашны хорио цээрийн агуулгагүй гэж үзсэн. Түүхийн хөгжлийн явцад нийгмийн харилцааны үндсэн нэгж байсан овог нь гэр бүлээр солигдсоноор “ачлал”-ын агуулга ихээхэн өөрчлөгджээ. Хятадын нэртэй эрдэмтэн Ли Зө Хоу (李泽厚) “Күнзийг дахин дүгнэх нь” (《孔子再评价》) хэмээх өгүүлэлдээ: “Күнз албадлагын шинж чанартай “ёслол” (礼) -ыг хүн амьдралдаа өөрөө ухамсарлах шинжтэй гүн ухааны ойлголт болгон дэвшүүлсэн бөгөөд “ёслол” (礼) нь сэтгэл зүйд л түшиглэнэ” хэмээжээ. Өөрөөр хэлбэл “сахиуслаг” (神) шинжтэй байсан “ёслол” (礼) нь хүний дотоод сэтгэл мөн чанарын эрэлхийлэл, ухамсрын шинжтэй болжээ. Ингэснээр ямарваа нэг “сахиуслаг” (神) шинжтэй зүйлд захирагддаг гэсэн үзэл өөрөө өөртөө захирагдах ёстой гэсэн үзлээр солигджээ. Энэ нь хятадын эртний үзэл санааны түүхэнд шинэ хуудас нээсэн²¹ байна.

Тэрчлэн “ачлал” нь ухамсарт түшиглэдэг хийгээд тэр нь аливаа хүний үүрэг, хариуцлагаар илэрдэг. Эцэг эх, ойр дотнын хүмүүстээ “ачлал”-тай байх нь нийгэмд хэрхэн хүрч нөлөөлөх вэ? гэдэгт Күнз, хүн бол зөвхөн хувь хүн байхаас гадна, нийгмийн гишүүн байдаг гэж үзжээ.

Иймээс эцэг эх, гэр бүлдээ “ачлал”-тай байхын зэрэгцээ өөрийн нийгэм дэх үүрэг хариуцлагаа ухамсарлаж байж өөрийгөө бусдын оронд тавьж бусдыг хайрлаж, энэрдэг.

Түүнээс гадна Күнзийн “ачлал” нь хэлбэрийн хувьд дараах онцлогтой.

1. “Шүүмжлэл өгүүлэл” зохиол нь харилцан яриа хэлбэртэй бөгөөд ярилцлагаас үзвэл Күнз “ачлал”-ын тухай өгүүлэхдээ тухайн харилцаж буй хүнийхээ онцлогт тохируулан өгүүлсэн байна. Тухайлбал, зохиолын “Засаглахуй” хэмээх хоёрдугаар бүлэгт өөрийн шавь Мэн И зы (孟懿子), Мэн Ү Бо (孟武伯), Зы Юй (子游), Зы Ся (子夏) нарыг “ачлал”-ын талаар асуухад Күнз хүн бүрт өөр өөр хариулт өгсөн байдаг.

2. Күнз “ачлал”-ыг хэрхэн үйлдэх талаар өгүүлсэн нь нэлээд олон байх бөгөөд энд ачлалыг үйлдэхийн утга учрыг чухалчилсан байна. Ли Зө хоу (李泽厚) -гийн өгүүлснээр: “Шүүмжлэл өгүүлэл” дэх “ачлалыг асууруун” (“问孝”), “өршөөлийг асууруун” (“问仁”) хэмээхийг “ачлалыг хэрхэн гүйцэтгэх”, “өршөөлийг хэрхэн гүйцэтгэх” гэж ойлговол зөв болно гэж үзсэн нь бий.

4. Күнзийн “ачлал” (孝) хийгээд “өршөөл” (仁) -ийн холбоо хамаарал

Күнзийн үзэл сургаалын хамгийн чухал ойлголт нь “өршөөл” (仁) хэмээдэг. Түүний “өршөөл”-ийг энгийнээр хэлбэл “хүнийг хайрлахуй”²² мөн.

Тэгвэл Күнзийн “ачлал” (孝) хийгээд “өршөөл” (仁) хэрхэн холбогдох вэ?

Юуны өмнө “ачлал” бол “өршөөл”, “өршөөлтэй байх”-ын үндэс суурь мөн. “Эцэг эхээ хүндэлж, ахас ихсээ хүндлэх нь өршөөлийн суурь буюу.”²³ Күнз, хүн гэр бүлдээ аав ээж, ахас ихэс, ах эгчээ хүндэтгэж байж бусдыг хайрлах энэрэх боломжтой гэж үзсэн. Өөрөөр хэлбэл гэр бүл, ойр дотнын хүмүүсээ ачлан хайрладаг байх нь хүн бусдыг хайрлан хүндлэх үндэс суурь гэж үзжээ.

Мөн “ачлал”-ыг хөгжүүлэн дэлгэрүүлснээр “өршөөл” болохыг

²¹ 李泽厚:《孔子再评价》,《中国社会科学》,1980年,02期,第9页。

²² Яан Юань хэмээхүйн арван хоёрдугаар бүлэг, хорин хоёрдугаар зүйл.

²³ Сурахуй хэмээхүйн нэгдүгээр бүлэг, хоёрдугаар зүйл.

заажээ. Күнзийн үзлээр “ачлалтай” хүн “өршөөлтэй” байх нь. “Күнз өгүүлрүүн: Дүү нар минь, эцэг эхийнхээ дэргэд ахуйд ачлагтун. Орон гэрээс одохуйн цагт ахас ихсийг хүндлэгтун. Үгээ цэнэж шударга байгтун. Ард олныг энэрэн, өршөөлт хүмүүнд ойр дөт байгтун.”²⁴ Гэр бүл бол нийгмийн хамгийн үндсэн нэгж. Хүн төрмөгцөө л гэр бүлийн харилцаанд орж аав ээж, ах эгчтэйгээ харилцдаг. Хэрвээ гэр бүл дотроо аав ээж, ах эгчээ ачлан хайрладаг бол нийгмийн харилцаанд бусдыг хүндэтгэх нөхцөл бүрдэнэ. Өөрийн аав ээжээ хайрлахгүй хүн хэрхэн бусдыг хайрлаж чадах вэ? Иймээс “ачлал” бол “өршөөл”-ийн урьдач нөхцөл, эхлэл болох бөгөөд “ачлал”-ыг өргөжүүлэн дэлгэрүүлдснээр тэр нь “өршөөл” болж түгнэ хэмээн үзсэн байна.

Дүгнэвэл, “Шүүмжлэл өгүүлэл” зохиолд Күнз “ачлал”-ыг гэр бүлийн ёс суртахууны төлөвшилд чухал нөлөөтэй гэж үзсэн бөгөөд улмаар нийгэмд, төрд ч ач холбогдлоо өгдөг гэж үзсэн нь тодорхой байна.

Энэ нь “нэгэн хүн Күнзээс асууруун: Та яагаад засаглалд эс зүтгэнэ вэ? Күнз өгүүлрүүн: “Засагт ном”-д: Ачлал болбоос, эцэг эхээ ачилж, ахан дүүсээ энэрэх аваас тэрхүү сэтгэл засаглалд түгэн хүртьюү” хэмээсэн бөлгөө. Энэ нь нь засаглалд зүтгэж буй хэрэг бус уу, хэрхэхийг засаглалд зүтгэв хэмээх буюу.”²⁵ хэмээснээс тодорхой харагдаж байна.

Ийнхүү Күнз ачлал буюу энэрч асрах, хүндэтгэлтэй байх, өршөөх тухай сургасныг шавь нар нь эмхтгэн түгээсэн нь хятадын ард түмний дунд үеэс үед дэлгэрсээр хятад хүний ёсонд эцэг эх, ахас ихсийг ачлан өргөх соёл гүнзгий нэвтэрчээ.

Энэ байдал нь хятад хүнийг ёс суртахуунтай байх, хятадын нийгэм дэг журамтай байх суурь нөхцөл болдог гэж үзэж өндөр үнэлдэг, дагадаг болох нь тодорхой байна.

Тиймээс ч хятадын ард түмэн эцэг эх тэргүүтэй ахмадууддаа гүн хүндэтгэлтэй

²⁴ Сурахуй хэмээхүйн нэгдүгээр бүлэг, зургаадугаар зүйл

²⁵ Засаглахуй хэмээхүйн хоёрдугаар бүлэг, хорин нэгдүгээр зүйл.

ханддаг бөгөөд тэдний эцэг эх, ахас ихсээс салах үеийн бэлэвсрэлийн дэг ёс, бэлэвсрэлийн дараах үеийн ахмадын сүнс, сүлдний тахилга тайлгын дэг ёсыг судлан учир холбогдлыг нь илрүүлэх нь Күнзийн “ачлал хийгээд “өршөөл”-ийг бүрэн тодорхойлоход ач холбогдолтой болно гэж үзэж байна.

Хятадын төрөөс ахмадыг асрах, бусдад өршөөлтэй хандах үзэл санааг хөхиүлэн дэмждэг нь гэр бүлийн ачлалаар дамжуулан нийгмийг бүхэлд нь эмх цэгцтэй байлгах Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл” зохиолын үзэл санааг эрхэмлэсээр байгаагийн илрэл болно.

НОМ ЗҮЙ

Нэг сэдэвт бүтээл:

1. 陈来: 《古代宗教与伦理——儒家思想的根源》, 北京: 三联书店, 1996年。
2. 康学伟: 《先秦孝道研究》, 长春: 吉林人民出版社, 2000年。
3. 肖群忠: 《孝与中国文化》, 北京: 人民出版社, 2001年。
4. 陈来: 《古代思想文化的世界》, 北京: 三联书店, 2002年。
5. 郭齐勇: 《中国哲学史》, 北京: 高等教育出版社, 2006年。
6. 李零: 《丧家狗——我读〈论语〉》, 太原: 山西人民出版社, 2007。
7. 王长坤: 《先秦儒家孝道研究》, 成都: 四川出版集团, 2007。
8. 李泽厚: 《〈论语〉今读》, 北京: 三联书店, 2008。
9. 杨伯峻: 《论语译注》, 北京: 中华书局, 2009。
10. 杜维明: 《体知儒学》, 杭州: 浙江大学出版社, 2012年。
11. 郭晓丽: 《钟泰学术思想研究》, 北京: 人民出版社, 2014年。
12. М.Чимэдцэе: 《Күнз 〈Шүүмжлэл өгүүлэл〉》 УБ. 2004

Эрдэм шинжилгээний өгүүлэл:

1. 李泽厚：孔子再评价，《中国社会科学》，1980（02）。
2. 杨华：春秋战国时期“宗统”与“君统”的斗争，《学术月刊》，1997（05）。
3. 郭晓丽：秦汉以来中国哲学主体意识的逻辑演变，《内蒙古大学学报》，2002（06）。
4. 王长坤，陈琪：略论孔子“孝”的思想，《孝感学院学报》，2004（001）。
5. 康娜：孔子孝思想及其现代价值研究，山东大学；硕士论文，2008-10-15。
6. 李振坡：《论语》之孝，首都师范大学；硕士论文，2008-04-30。
7. 师爽：《论语》中“孝”思想探析，《船山学刊》，2009（02）。
8. 赵正杰：孔子的孝的思想及其当代价值，南京大学；硕士论文，2014-06-03。

Abstract: Chinese Spring and Autumn period is thought to be a period of profound changes and reform in ancient China. This reputation mainly rests on all aspects of social changes that happened during this period, including political, economic, and cultural reforms. Most notably, in regards to education at that time in ancient China, “private schools” prospered side by side with state-run public schools that were only attended by youth of nobility and elite families. This led to scholars and intellectual masters giving private tuition to people from all walks of life and general education that was reserved exclusively for those in the upper class of society soon became available to ordinary citizens. Over the years, this critical change in education and schooling set the foundation for “letting

one hundred flowers bloom and one hundred schools of thought contend”. Many great thinkers emerged during this period and one of them was Confucius. He is considered among the great thinkers of his time and beyond, and lived for spreading his knowledge and doctrine.

Confucius (551 BC) was born in Lu nation (鲁) in ancient China, present day Qufu city in Shandong province. He was left orphaned by his father at the age of 2, and was brought up by his single mother, who had a high regard for the importance of order and discipline. He attended school from a young age and having a highly educated and morally righteous scholar as his private tutor may have helped shape his mind, conscious and critical thinking, and his overall view of life.

Among Confucius’ vast array of literary and philosophical works, his teaching and doctrine may have been best expressed in his work “The Analects of Confucius”/“Criticism Article”. “Benevolence” (仁) and “Piety” are at the core of Confucius’ teaching and with “The Analects of Confucius”/“Criticism Article”, we aimed to shed light on how Confucius’ doctrine of “piety” expressed in this particular literary work. Historically, The Spring and Autumn period lasted from around 770 to 476 BC and Confucius is considered the founder and exponent of the first ever such school in China